



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
БОЛОВСРОЛ, СОЁЛЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ
**НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ
СУРГУУЛЬ**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Бага тойруу, Утас: 32 84 50, <http://www.msue.edu.mn>

2016.12.26 № 1/483
танай _____ -ны № _____ -т

Орос хэлний олимпиадын тухай

Орос хэлний улсын олимпиадад эхний байр эзэлсэн сурагчдыг ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр ОХУ-ын их дээд сургуульд үнэ төлбөргүй суралцах эрхээр шагнах бөгөөд эрх авсан сурагчдын материалыг бүрдүүлж, 3-р сарын 05 гэхэд ОХУ-ын Боловсрол, шинжлэх ухааны яаманд хүргүүлсэн байх шаардлагатай учраас 2016 оны олимпиадын хуваарьт дараах өөрчлөлтийг оруулахаар БСШУСЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Суурь, бүрэн дунд боловсролын хэлтсээс шийдвэрлэсэн болохыг үүгээр мэдэгдэж байна. Үүнд:

1. Орос хэлний олимпиадын 1-ийн давааг тус тусын сургууль дээр,
2. 2-ын давааг 2017 оны 01 дүгээр сарын 20-нд нийслэл, аймгийн төвд,
3. 3-ын давааг 2017 оны 02 дугаар сарын 20,21,22-ны өдөр Улаанбаатар хотод тус тус зохион байгуулна. 3-ын даваанд оролцогчдыг 02-р сарын 20-ны өдрийн 09.00-15.00 цагийн хооронд МУБИС-ийн НХУС-ийн Орос хэлний тэнхим дээр буюу 207 тоотод бүртгэнэ.

Олимпиадыг уламжлал ёсоор 9-р анги энгийн, гүнзгий, 12-р анги энгийн, гүнзгий, багш гэсэн 5 номинациар явуулах бөгөөд 3-ын даваанд аймаг бүрээс тус бүр 12-р ангийн 2 (энгийнээс 1, гүнзгийгээс 1, гүнзгий бүлэггүй тохиолдолд энгийн бүлгийн эхний 2) хүүхэд заавал ирүүлнэ. 9-р ангийн хувьд гүнзгий бүлэггүй бол энгийн бүлгийн 1 ялагчийг л ирүүлнэ. Аварга сурагчдыг аймгийн аварга болсон орос хэлний багш ахалж ирнэ.

9,12-р ангийн сурагчдын олимпиадад доод ангиас дэвшүүлэн оролцуулахыг хатуу хориглоно. Анги дэвшиж 12-р ангийн аварга болж ирсэн хүүхдийг улсын олимпиадад бүртгэхгүй бөгөөд үүнтэй холбогдон үүсэх санхүүгийн зардал, гомдол саналыг тухайн аймаг, нийслэлийн БСГ-ын холбогдох мэргэжилтэн хариуцаж барагдуулна.

ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр ОХУ-ын их дээд сургуульд үнэ төлбөргүй суралцах эрхээр шагнагдах болзлыг хангасан сурагч бүрэн дунд боловсролын гэрчилгээндээ нэг ч "С" үнэлгээгүй байх ёстой ба ийм үнэлгээтэй тохиолдолд дараагийн байр эзэлсэн сурагчдаас шалгаруулалт хийнэ.

Жич: Олимпиадын 2-ын давааны материалыг аймаг, нийслэлд 2017 оны 01-р сарын 20-ны өдрийн 10.00 цагт нэгэн зэрэг задалж, задалмагц олшруулан олимпиадын үйл ажиллагааг эхлүүлнэ. Бүрэн дунд болон суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотойгоор олимпиадын материалын агуулгад ТРКИ-ийн стандарттай уялдуулсан зарим өөрчлөлтийг оруулсан болно.

БСШУСЯ-НЫ ОРОС ХЭЛНИЙ
НИЙГЭМ,
ХҮМҮҮНЛЭГИЙН
УХААНЫ
СУРГУУЛЬ
ДЭД ХОРООНЫ ДАРГА



доктор, дэд проф. Ш.Цолмон